

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠠᠷᠬᠠᠩᠭ᠋ᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮР АШИГ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН
ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД:
АРА-2022/22-1-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2022 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatard@audit.gov.mn
Багийн ахлагч, ахлах аудитор Х.Алтанчимэг
Утас: 9006-0105 Цахим хаяг: altanchimegkh@audit.gov.mn
Аудитор Г.Цог-Эрдэнэ
Утас: 9921-0906 Цахим хаяг: tsogerdeneg@audit.gov.mn
Аудитор Ж.Мөнгөншагай
Утас: 90909190 Цахим хаяг: mongonshagaij@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА	3
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ	5-6
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	6-8

БҮЛЭГ 1: КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ОРОН НУТАГТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

- 1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаний засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.
- 1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.

- 2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, батлахгүй байна.
- 2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
- 2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангасан эсэхэд шинжилгээ хийж ажиллахгүй байна.
- 2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж ажиллахгүй байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

- 3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тавих хөндлөнгийн хяналт хангалттай байгаа ч, үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.
- 3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна
- 3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг ханган ажиллаж чадахгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	28
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	29
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	30
ТАЙЛАН БАТАЛСАН ТУШААЛ.....	34



Товчилсон үгийн тайлбар:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хуралын тэргүүлэгчид
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
УИХ	Улсын их хурал
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТБОНӨААТҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2019-2021 онуудын ОНӨААТҮГ-ууд орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэл	6
Хүснэгт 2	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2021 оны ашигт ажиллагааны үзүүлэлт	7
Хүснэгт 3	2021 оны Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт	8
Хүснэгт 4	2016-2020 оны засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт	11
Хүснэгт 5	ТУЗ-ын 2019-2021 оны ажил	13
Хүснэгт 6	ОНӨААТҮГ-ын эдийн засгийн төлөвлөлт	14
Хүснэгт 7	ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшинээ хянаж батлуулсан байдал	15
Хүснэгт 8	ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	16
Хүснэгт 9	Татварын орлогын гүйцэтгэл	18
Хүснэгт 10:	Зардлын гүйцэтгэл	21
Хүснэгт 10	2019-2021 онуудад ОНӨААТҮГ-уудад хяналт шалгалтыг хийсэн байдал	20



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР:

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг”

АУДИТЫН КОД:

АРА-2022/22-1/ШТА-ГА

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
3. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тавих хяналт үр нөлөөтэй эсэх.

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Аудитад аймгийн ИТХ, Засаг дарга, Эрдэнэмандал, Чулуут сумын ИТХ, Орон нутгийн өмчийн газар, “Ар-Ус Ундарга” ОНӨААТҮГ, “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ, “Цөм сүрэг” ОНӨААТҮГ, “Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ, Эрдэнэмандал сумын “Шилмэл сүргийн төв”, “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ хуулийн этгээдүүдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, Төлөөлөн удирдах зөвлөл 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн



аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 тоот тушаал “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 тоот тушаал “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.

АУДИТ ХИЙСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд Ахлах аудитор Х.Алтанчимэг, аудитор Г.Цог-эрдэнэ, Ж.Мөнгөншагай нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 сарын 16-наас эхлэн гүйцэтгэж 2022 оны 07 сарын 01-нд Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, аймгийн ИТХ, засаг дарга, шалгагдагч байгууллагууд болон ҮАГ-т хүргүүллээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАСАН МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан ТӨХК, ОНӨААТҮГ 2 салгаж тусдаа бичлээ. “Ар Ус Ундарга ХХК”-ны 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн СХАА-аас шалгалт хийж илэрсэн алдаа зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тул тус байгууллагын илрүүлэлт дэх асуудлыг 2-р бүлгийн Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэхэд дурьдсан болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 1996 онд баталсан бөгөөд тус хуульд 29 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 77, 78 дугаар зүйлд төрийн болон орон нутгийн өмчийн талаар дараах байгууллагын эрхийг хуульчилсан байна.

Тухайлбал:

- *ИТХ нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх, орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах, орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих*
- *Засаг дарга: иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох; орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын Тэргүүлэгчдэд оруулах; орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг*

зохион байгуулах; орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах; орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах;

- **ОНӨГ:** Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх, эд хөрөнгийн анхан шатны бүртгэл тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулах удирдах, Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох, хяналт тавих

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор өөрийн өмчөөр дангаар, нийтийн болоод хувийн холимог өмчөөр хуулийн этгээд байгуулж болох хуулийн зохицуулалттай бөгөөд Архангай аймагт 2021 оны жилийн эцсийн байдлаар Эрдэнэмандал сумын Шилмэл сүргийн төв, Дэд бүтэц ОНӨААТҮГ-ууд нь шинээр байгуулагдаж нийт 6 орон өмчит хуулийн этгээдтэй болсон байна. Аудитад 6 орон нутгийн өмчит хуулийн этгээд хамрагдан шалгагдлаа.

ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын шийдвэрээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1: 2019-2021 онуудын ОНӨААТҮГ-ууд орлого, зардлын төлөвлөгөө гүйцэтгэл

№	Он	Байгууллагын нэр	Орлого	Зардал	Зөрүү	Хувь
1	2019	Ар Ус Ундарга ХХК	1,089.1	1,114.1	(25.00)	2.30
	2020		910.4	986.5	(76.10)	8.36
	2021		1,404.7	1,476.6	(71.90)	5.12
2	2019	Цөм сүрэг	143.2	43.2	100.00	(69.83)
	2020		71.2	40.4	30.80	(43.26)
	2021		21.9	21.2	0.70	(3.20)
3	2019	Архангайд үйлдвэрлэв	83.9	106.0	(22.10)	26.34
	2020		208.6	230.8	(22.20)	10.64
	2021		197.3	228.2	(30.90)	15.66
4	2020	Чулуут ахуйн үйлчилгээ	36.2	30.5	5.70	(15.75)
	2021		33.8	33.8	-	-
5	2021	Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц	38.9	38.9	-	-
6	2021	Шилмэл сүргийн үржлийн төв	2.1	2.1	-	-

*2019-2021 оны аудитлагдсан орлого, үр дүнгийн тайлангаас

1. “Ар Ус Ундарга” ОНӨААТҮГ: Аж ахуй нэгж байгууллага, иргэдийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангаж, бохир усыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр татан зайлуулж, хөнгөн шуурхай үйлчлэх зорилготойгоор 1941 онд байгуулагдсан байна. Сүүлийн 3 жилийн гүйцэтгэлээр алдагдалтай ажилласан байна.

2. Цөм сүрэг үржлийн төв” ОНӨААТҮГ: Аймгийн ИТХ-ын 2017 оны 3 дугаар сарын 18-ны 11 тоот тогтоолоор байгуулагдсан. Хээлтүүлэгч, хээлтэгчийн үржлийн тохироог хангах иргэд, аж ахуй нэгжийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэх санаачлагыг дэмжиж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мал үржлийн ажлын дэвшилтэт арга

технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, өөрийн сүргээс үржлийн жишигт тэнцсэн хээлтүүлэгч бойжуулан, борлуулж өөрөө өөрийгөө санхүүжүүлэх үндсэн зорилго чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

3. Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ: Аймгийн ИТХТ-ийн 2018 оны 10 сарын 10-ны 43-р тогтоолоор “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ-ын дүрмийг баталсан бөгөөд дүрэмд зааснаар аймгийн иргэдийн үйлдвэрлэж, бий болгосон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байраар хангах, гадаад дотоод худалдаа эрхлэх чиг үүрэг бүхий үйлдвэрийн газар юм. Тухайн байгууллага нь 2019 оны 04 сарын 1-нд улсын бүртгэлийн гэрчилгээ авч 5 сарын 1-ээс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

4. “Чулуут-Ахуй үйлчилгээний төв” ОНӨААТҮГ: Аймгийн ИТХТ-ийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор байгуулагдсан. Сумын иргэдийг үйлдвэрлэл эрхлэх нөхцөл боломжоор хангах, үйлвэрлэж бий болгосон бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж ажлын байраар хангах чиг үүрэг бүхий ОНӨААТҮГ юм.

5.6. “Шилмэл сүргийн үржлийн төв”, “Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ыг Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2021 оны ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 05, 06 дугаар тогтоолуудаар тус тус байгуулагдсан.

Хүснэгт 2: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2021 оны ашигт ажиллагааны үзүүлэлт

/сая.төг/

Байгууллагы нэр	Он	Орлого	Зардал	Татварын өмнөх ашиг	Татварын зардал	Ашиг/ алдагдал
Ар-ус ундарга” ОНӨААТҮГ	2021	168.13	239.99	(71.85)	-	(71.85)
“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГ	2021	197.25	228.21	(30.96)	-	(30.96)
“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ	2021	21.94	21.10	0.84	0.08	0.76
“Чулуут Ахуй үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	2021	35.18	58.82	(23.64)	-	(23.64)
“Шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ	2021	3.35	2.11	1.24	-	1.24
“Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ	2021	38.94	38.92	0.02	-	0.02

Эх сурвалж: 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

Хүснэгтээс харахад 2021 оны жилийн эцсийн байдлаар ТБОНӨААТҮГ-ын 50 хувь нь ашиггүй ажилласан байна.

Аудитын урьдчилсан судалгаагаар 2021 оны жилийн эцэст орон нутгийн өмчит 6 хуулийн этгээдийн 8,006.2 сая төгрөгийн, төрийн өмчит 1 хуулийн этгээдийн 1,411.1 сая төгрөгийн хөрөнгө балансад бүртгэлтэй байна. /Эх сурвалж: 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан/.



Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулдаг бөгөөд Эрдэнэмандал сумын “Шилмэл сүргийн үржлийн төв”, “Эрдэнэмандал Хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулаагүй байна. Харин бусад хуулийн этгээдэд дараах зөрчил илэрсэн байна.

Хүснэгт 3: 2021 оны Санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт

Байгууллагын нэр	Үзүүлэлт	НББ, тайлагнал		Арвилан хэмнэлт,		Хууль, тогтоомжийн хэрэгжилт		Дотоод хяналт, хариуцлага		Худалдан авалт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ар ус ундарга ХХК	Төлбөрийн акт	1	2.73		0		0				
	Албан шаардлага	1	116.4	1	1.45	4	127.0				
	Зөвлөмж	2	2.1								
	Залруулсан алдаа	3	91.1								
Архангайд үйлдвэрлэв	Албан шаардлага	1	7.2								
	Зөвлөмж	1	0.2								
	Залруулсан алдаа	2	7.4								
Цөм сүргийн үржлийн төв	Албан шаардлага		9.2								
	Зөвлөмж		0			2	4.1				
Чулуут ажуй үйлчилгээний төв	Албан шаардлага		0								
	Зөвлөмж		0								

Эх сурвалж: 2021 оны СТА-ын дүн

Нийт алдаа зөрчлийн 51 хувийг нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил илэрсэн нь орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн санхүү бүртгэлтэй холбоотой дотоод хяналт хангалтгүй байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 5.2.19-т “Төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэглүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай үр дүнтэй явуулна.” Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйнд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ОРОН НУТАГТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.



1.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаний засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.



1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компаний засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд орон нутгийн өмчийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих, өмчийн харилцааг зохицуулах талаар илүү дурьдснаас орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг зохицуулах талаар хангалттай тусгаагүй байна. Компаний тухай хуулийн 2.3-т¹ зааснаар төрийн өмчит ХК, ХХК байгуулж тус хуулиар зохицуулахаар заасан боловч ХК, ХХК-ний хяналтыг төрөөс хэрхэн хэрэгжүүлэх талаар дурьдаагүй нь эдгээр хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.



1.1.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх үндэсний зарчим, аргачлал нэгдсэн байдлаар батлах шаардлагатай.

Орон өмчит үйлдвэрийн газруудын засаглалын хэлбэр нь ХК, ХХК, ТӨҮГ ОНӨААТҮГ, ОНӨХХК зэрэг бүтэцтэй байхаар хуульчилжээ. Гэтэл ижил үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын засаглалын хэлбэр өөр өөр байна. Тухайлбал:

Ус суваг ашиглалтын чиглэлээр 21 аймагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагын 4 нь ОНӨХХК, 17 нь ОНӨААТҮГ байна. Эдгээр 4 Ус суваг ашиглалтын ОНӨХХК нь үйл ажиллагаагаа компаний тухай хуульд нийцүүлэн явуулж байгаа нь төрөөс тавих хяналтыг бууруулж байна.

Иймд компаний засаглалыг үнэлэх нэгдсэн бодлого аргачлалыг бий болгосноор ус суваг ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОНӨХХК-д тавих хяналт сайжирч үйл ажиллагааны хэлбэр оновчтой болохоор байна.



1.1.3. Төрийн эрх бүхий байгууллага хууль, эрх зүйн баримт бичиг хоорондын уялдааг хангаж, чиг үүргээ зохистой түвшинд хэрэгжүүлэхгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд аймгийн ИТХ, Засаг дарга, ОНӨГ-ууд ТБОНӨААТҮГ-тай хамтран ажиллах талаар тусгажээ. Үүнд:

1. ИТХ-ын бүрэн эрх: Хуулийн 77-р зүйлд ИТХ-ын бүрэн эрхийг тусгасан бөгөөд ИТХ нь тухайн аймаг, сум, нийслэлийнхээ өмчийг хүн амаа төлөөлөн өмчилж, хяналт тавих, үр ашгийн тайлан тооцоо судалгаа

¹ 2.5. Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.

- үнэлж дүгнэлт өгч, ОНӨҮГ байгуулах татан буулгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.
2. Засаг даргын бүрэн эрх: Хуулийн 78-р зүйлд Засаг даргын бүрэн эрхийг тусгасан бөгөөд ИТХ-аас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, ОНӨҮГ-ын эрх баригчдыг томилж, чөлөөлөх үйл ажиллагааг явуулж байна.
 3. ОНӨГ-ын бүрэн эрх: Хуулийн 11-р зүйлд ОНӨГ-ын бүрэн эрхийг тусгасан бөгөөд эд хөрөнгөд хяналт тавих, ОНӨҮГ-т мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, төрийн өмчийн оролцоотой этгээдэд төрийн өмчийн төлөөлөгч томилож ажиллуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Орон нутагт ТБОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, бодлого арга зүйгээр хангаж, ажиллах байгууллага нь ОНӨГ бөгөөд хууль эрхзүйн баримт хоорондын уялдааг хангаж зохистой түвшинд хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэвч хуульд заасан энэ үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



1.2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого алдагдсан байна.

Аймгийн ИТХ нь 2020 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор Ар Ус Ундарга ХХК, Цөм Сүрэг, Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын Эзэмших эрхийг Эрдэнэбулган суманд шилжүүлжээ. Тус тогтоолоор 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 7 дугаар тогтоолоор хүчингүй болгож, Эрдэнэбулган сумын болон Аймгийн ИТХ-ын хооронд өмчлөлийн маргаан гарч захиргааны ерөнхий хуулиар шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны 109/ШЗ2021/0367 тоот шийдвэрээр тус байгууллагын эзэмшигч нь аймгийн ИТХ байхаар тогтоосон.

Аудитад хамаарах хугацаанд дээрх байгууллагуудын засаглал хөгжүүлэх тогтвортой бодлого алдагдсан, түүнд аймгийн засаг дарга, ОНӨГ-аас хяналтыг хэрэгжүүлдэггүй, бодлого арга зүйгээр хангаж ажиллах байдал хангалтгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5², 11.6³ дахь заалтыг зөрчсөн байна.

- ✓ **Ар Ус Ундарга ХХК:** Аудитад хамаарах хугацаанд тус байгууллагын удирдлагад 6 удаа өөрчлөлт орсноор ОНӨХХК-ын үйл ажиллагааны компанийн засаглалын бодлого алдагдсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор дүрмийг шинэчлэн бүртгүүлж тус байгууллага улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр

² 5/ орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

³ 6/ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих;

авсан байна. Гэтэл гэрчилгээнд тус байгууллагын хариуцлагын хэлбэрийг ХХК-иар тусгаж, хувьцаа эзэмшигчийн мэдээллийг шинэчлээгүй, эцсийн өмчлөгчийг иргэнээр тусгасан байгаа нь дээрх ИТХ-аар батлагдсан дүрмийн 1.5⁴ дахь заалт буюу "Компани нь 100 хувь орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд өмчлөгчийн эрхийг аймгийн ИТХ хэрэгжүүлнэ гэсэн заалтыг зөрчсөн байна.

"Чулуут ахуйн үйлчилгээний төв" ОНӨААТҮГ: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4⁵ дэх хэсгийг үндэслэн аймгийн ИТХТ-ээс "Чулуут-Ахуй үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ыг байгуулж, дүрмийг баталжээ. Уг ОНӨААТҮГ-ын дүрэмд чиг үүргийг тодорхой тусгаж өгсөн хэдий ч Аймгийн ИТХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.2.1⁶, ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.6⁷, 6.7.9⁸, 7.3⁹, 9.3¹⁰ дэх заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэхэд "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компаний засаглал хөгжүүлэх бодлого алдагдсан байна"



1.2.2. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төрийн болон орон нутгийн өмчийн засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулах зорилтын хүрээнд арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-4 2016-2020 оны засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

Байгууллагын нэр	Арга хэмжээний тоо		Хэрэгжилт /хувь/
	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	
Ар Ус Ундарга	3	14	80
Цөм сүрэг	1	3	100
Архангайд үйлдвэрлэв	1	4	100
Чулуут ахуйн үйлчилгээ	1	1	100
НИЙТ	5	22	95

1. Ар Ус Ундарга ХХК-ний үйл ажиллагаатай холбоотой дараах 3 хөтөлбөрт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- I. Цэцэрлэг хотын цэвэр усны эх үүсвэрийн харуул хамгаалалтыг сайжруулж, хяналтын систем нэвтрүүлэн, ундны усны шинэ эх үүсвэртэй болгож, цэвэр усны худгуудыг нэгдсэн системд холбох ажлыг эхлүүлэн усыг зүй зохистой

⁴ Компани нь 100 хувь орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд өмчлөгчийн эрхийг аймгийн ИТХ хэрэгжүүлнэ

⁵ 77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

⁶ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

⁷ "Орон нутгийн өмчийн газар нь үйлдвэрийн газрыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана

⁸ "үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулах үүрэгтэй"

⁹ Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллана

¹⁰ Үйлдвэрийн газар нь үйл ажиллагааныхаа тайланг Санхүү, төрийн сангийн хэлтэст, тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн тайланг ОНӨГ-т хүргүүлнэ

ашиглах, ард иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлсэн усаар хангах бодлого баримтлана /5 арга хэмжээ /

- II. "Ус, дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгаж, цаашид үе шаттай бууруулах бодлого баримтлана" /2 арга хэмжээ/
- III. "Цэцэрлэг хотод дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж барина. /2 арга хэмжээ/

2. Цөм сүрэг ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой дараах 1 хөтөлбөрт 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- I. Малын удмын сан генетик нөөцийг сайжруулах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн нийт сүрэгт цөм сүргийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэн, шинэ үүлдэр, омгийг бий болгохыг дэмжинэ./3 арга хэмжээ/

3. Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой дараах хөтөлбөрт 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- I. "Архангайд үйлдвэрлэв" төв байгуулж үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүнээ сурталчлах, зах зээлд нийлүүлэх, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийн бүтээгдэхүүнийг борлуулах сувгуудыг нээж өгөх бизнес уулзалт үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна. /4 арга хэмжээ/

4. Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨӨТҮГ-ийн үйл ажиллагаатай холбоотой 1 заалт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- I. "Ахуй үйлчилгээний төв"-ийн барилгыг засах, байнгын ажлын байрыг нэмэгдүүлнэ./ 1 арга хэмжээ/ - Аймгийн Засаг даргын нөөц сангаас 5.0 сая төгрөгийн, өөрийн эх үүсвэрээс 1.0 сая төгрөгийн санхүүжилт гаргаж чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын байрны дээврийн засвар хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс ирүүлсэн тайланд дээрх арга хэмжээний хэрэгжилтийг хангалттай хэмээн дүгнэжээ. /Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ны хэлтсийн 2022 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 09/1097 тоот албан бичиг /



1.2.3. аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, компанийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүнд: 4.2.5. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно” гэсэн заалтын хүрээнд 2 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Биелэлтийн хугацаа болоогүй байна. Харин 2021 онд “Эрдэнэмандал суманд шинээр Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц”, Шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ байгуулагдсан бөгөөд эдгээр газруудын үйл ажиллагааны талаар засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй байна.



1.2.4. Ар Ус Ундарга ХХК-иас бусад ОНӨААТҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлөгүй байна.

А. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 09 сарын 20-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Ар Ус Ундарга ХХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийг анх байгуулж 2020 оны 7 сарын 30-ны 36 дугаар тогтоолоор шинээр 7 хүний бүрэлдэхүүнтэй өөрчилсөн байна

Хүснэгт 5: ТУЗ-ын 2019-2021 оны ажил

Он	Байгууллагын нэр	ТУЗ-ын гишүүдийн тоо	Хуралдсан байдал	Шийдвэрлэсэн асуудлын тоо
2019	Ар Ус Ундарга ХХК	7	11	11
2020			3	3
2021		Байхгүй	0	

Аймгийн ИТХ-ын 2017 оны 02 сарын 01-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “ТУЗ-ийн

ажиллах журам”-ын 3.9-д “... компаний аппаратын үйл ажиллагаанд хяналт тавих... үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана” гэж заасны дагуу 2019-2020 он нийт 13 удаагийн хурлаар 13 асуудлыг шийдвэрлэсэн байна.

Гэвч аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Өмчлөх эрх шилжүүлэх тухай” 51 дүгээр тогтоолоор Ар Ус Ундарга ХХК-ны өмчлөх эрхийг Эрдэнэбулган суманд шилжүүлснээр компаний дүрэмд өөрчлөлт орж ТУЗ-ын бүрэн эрх, үйл ажиллагааг хүчингүй болгосноор тус компани нь **2020 оны 7 сараас эхлэн 2021 оны турш ТУЗ-гүй ажилласан.** Өмчлөх эрхийн маргаан эцэслэгдэн шийдэгдснээр аймгийн ИТХ-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны 14 тогтоолоор ТУЗ-г 7 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан, Шинэчлэн байгуулсан ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8¹¹-д заасан шалгуурыг хангаагүй байна.

Иймд шалгуурыг хангасан гишүүдийг томилж, ТУЗ-ийн 2017 оны 02 сарын 01-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “ТУЗ-ийн ажиллах журам-д заасан чиг үүргийн дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж, эдийн засгийн зорилтот түвшинг үндэслэлтэй хянаж батлан аймгийн ИТХ-д танилцуулж ажиллах албан шаардлагыг хүргүүлж байна.

Б. Архангайд үйлдвэрлэв, Цөм сүрэг, Чулуут ахуйн үйлчилгээ нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр батлагдсан төлөөлөн удирдах зөвлөлөгүй, ОНӨААТҮГ-ын дүрэмд зааснаар аймгийн засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.

В. Харин 2021 онд шинээр байгуулагдсан Эрдэнэмандал сумын “Шилмэл сүргийн үржлийн төв”, Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ нь дүрмэндээ заасны дагуу 7 хүний бүрэлдэхүүнтэй ТУЗ-г байгуулсан байна.

¹¹ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Цаашид ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд ТУЗ-ыг зайлшгүй ажиллуулах шаардлагатай байгаа тул дээрх үйлдвэрийн газруудын дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.



2.1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, батлахгүй байна.



2.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөхгүй байна.

Ар Ус Ундарга ХХК: 2019-2020 оны эдийн засгийн зорилтот түвшнийг холбогдох эрхзүйд нийцүүлэн төлөвлөсөн ч 2021 оны эдийн засгийн тооцоо судалгаа хангалтгүй байна.

Хүснэгт 6: ОНӨААТҮГ-ын эдийн засгийн төлөвлөлт

№	Он	Орлого	Зардал	Ашиг алдагдал	ТУЗ-ын баталсан огноо дугаар
1	2019	1,161.82	1,132.61	29.21	2019 оны 05 дугаар тогтоол
2		1,161.82	1,175.38	(13.56)	2019 оны 8 дугаар тогтоол
3	2020	910.44	986.53	(76.09)	2020 оны 01 дүгээр сарын 01 тогтоол
4	2021	-	-	-	ТУЗ-гүй ажилласан тул эдийн засгийн зорилтот түвшинг батлаагүй.

2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлтийг харахад тус компани нь үйл ажиллагааны үр ашгийг алдагдалтай баталжээ. Тухайлбал: 2019 онд 13.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөгөөг батлуулсан бол гүйцэтгэлээр 24.9 сая төгрөгийн, 2020 онд 156.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллах төлөвлөгөөг батлуулж гүйцэтгэлээр 76.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь 2019 оноос эхлэн шинээр цэвэрлэх байгууламж ашиглалад орсноор үйл ажиллагааны зардал нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин 2021 оны бизнес төлөвлөгөө боловсруулаагүйгээс шалтгаалан эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй тооцсон эсэхийг тулган шалгах боломжгүй байлаа.

“Чулуут ахуйн үйлчилгээний төв” ОНӨААТҮГ: Аймгийн ИТХ-ын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны 37 тогтоолоор батлагдсан Чулуут ахуй үйлчилгээний төвийн дүрэмд зааснаар сумын иргэдийг үйлдвэрлэл эрхлэх нөхцлөөр хангах зорилготой, түрээсийн орлогоор үйл ажиллагаа байгуулагдсан ОНӨААТҮГ юм. Орлогыг төлөвлөхдөө талбайн түрээсийн үнээр түрээслэгч нарт ногдуулалт хийж ажилладаг. 2021 онд Нийт 546м² талбайг 20 иргэнд түрээслэж 31.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж ажилласныг түрээслэх үнийн тарифийг түрээслэгч тус бүрээр ногдуулан тулгалт хийхэд 0.2 сая төгрөгөөр илүү тооцож батлуулсан.

Иймд Талбайн түрээсийг түрээслэгч тус бүрээр үнэн зөв тооцож сумын ИТХТ-ээр батлуулж байх талаар зөвлөмжийг хүргүүлээ.

2. Цөм сүрэг ОНӨААТҮГ: ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар АРА-2022/22-1/ШТА-ГА

батлуулан биелэлтийг хангах”, үржлийн төвийн дүрмийн 7.4-д "Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тайлагнана" гэсэн заалтуудын хэрэгжилтийг тулган шалгахад 2019-2021 онд санхүүгийн төлөвлөгөө гаргаагүй байна.

Тухайн жилд байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах зардлын зүйл тус бүрт тооцоо судалгаа хийж бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн холбогдох байгууллага, албан тушаалтнаар хянуулан батлуулан ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3. Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ: Тус ТБОНӨТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, үйлдвэрийн газрын дүрмийн 6.7.9 "Үйлдвэрийн газрын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж биелэлтийг хангуулах үүрэгтэй" гэсэн заалтуудын дагуу 2020, 2021 онд санхүүгийн төлөвлөгөө гаргасан хэдий ч үндэслэлтэй төлөвлөөгүйгээс зардлын зүйл анги тус бүрд 1.4-26.3 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс хэтрүүлсэн зөрчил илэрсэн.

Үйлдвэрийн газрын төсвийг төлөвлөхдөө зардлын зүйл тус бүрт тооцоо судалгаа хийж үндэслэлтэй төлөвлөж байх албан шаардлага хүргүүлж байна.



2.1.2. Орон нутгийн өмчид хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаас хянаагүй байна.

Ар Ус Ундарга ХХК: ТУЗ-өөс Ундарга ХХК-ний эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллагаас хянасан анхан шатны нотлох баримт ирүүлээгүй. Бизнес төлөвлөгөөг болосвруулсан байдалтай танилцахад 2019-2020 онуудад ТУЗ-д төлөвлөгөөг танилцуулж батлуулсан нь нэг талаар хяналтыг хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна. Гэвч 2021 онд ТУЗ-гүй ажилласнаар эдийн засгийн зорилтот түвшнийг хянах эрх бүхий албан тушаалтангүй байсан нь хөрөгийн үр ашиггүй зарцуулалтыг нэмэгдүүлжээ.

Бусад ОНӨААТҮГ-ын хувьд аймаг сумдын засаг даргатай гэрээ байгуулан ажилладаг бөгөөд эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлтэй хянаж батлахгүй байна.



2.1.3. 2021 онд орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтот түвшнийг эрх бүхий байгууллага хянаж батлаагүй байна.

Хүснэгт 7: ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшнээ хянаж батлуулсан эсэхийг хүснэгтээр харуулбал:

Он	Байгууллагын нэр	Хянаж батлах эрх бүхий байгууллага	Хянасан эсэх	Баталсан эсэх
2019	Ар Ус Ундарга	ТУЗ	тийм	тийм
	Архангайд үйлдвэрлэв	Аймгийн засаг дарга	тийм	тийм
	Цөм сүрэг	Аймгийн засаг дарга	тийм	тийм
2020	Ар Ус Ундарга	ТУЗ	тийм	тийм
	Архангайд үйлдвэрлэв	Аймгийн засаг дарга	тийм	тийм
	Цөм сүрэг	Аймгийн засаг дарга	тийм	тийм
	Чулуут ахуйн үйлчилгээний төв	Чулуут сумын засаг дарга	тийм	тийм

2021	Ар Ус Ундарга	Эрдэнэбулган сумын засаг дарга	үгүй	үгүй
	Архангайд үйлдвэрлэв		үгүй	тийм
	Цөм сүрэг		үгүй	үгүй
	Чулуут ахуйн үйлчилгээний төв	Чулуут сумын засаг дарга	үгүй	үгүй
	Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц	Эрдэнэмандал сумын ТУЗ	тийм	тийм
	Шилмэл сүргийн үржлийн төв		тийм	тийм

Хүснэгтээс харахад 2021 онд ОНӨААТҮГ-уудыг эрх бүхий байгууллагаас эдийн засгийн зорилтот түвшнийг хянаж батлаагүй байна. Энэ нь өмчлөлийн маргаан гарч ОНӨААТҮГ-ууд Эрдэнэбулган сумын засаг даргатай гэрээ байгуулан ажилласнаас шалтгаалан дотоод хяналт алдагдсантай холбоотой байна.

2.2.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.



2.2.1.Орон нутгийн өмчит хуулийн этгээд төлөвлөсөн орлогоо 489.9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8: ОНӨААТҮГ-ын 2019-2021 оны орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Он	Байгууллагын нэр	Орлогын			Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	2019	Ар Ус Ундарга ХХК	1,161.8	1,089.1	72.7	(6.3)
	2020		1,007.2	910.4	96.8	(9.6)
	2021		1,598.1	1,404.7	193.4	(12.1)
2	2019	Цөм сүрэг		33.2	(33.2)	100.0
	2020			35.7		100.0
	2021			18.6	(18.6)	100.0
3	2019	Архангайд үйлдвэрлэв		75.2	(75.2)	(15.7)
	2020		154.3	160.2	5.9	3.8
	2021		192	197.2	(5.2)	2.7
4	2020	Чулуут ахуйн үйлчилгээ	36.2	30.5	5.7	(15.7)
	2021		31.3	27.0	4.3	(13.7)
5	2021	Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц	38.9	38.9	-	-
6	2021	Шилмэл сүргийн үржлийн төв	2.1	2.1	-	-

Хүснэгтээс харахад ОНӨААТҮГ-д бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан орлогоо 489.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ.

1. Ар Ус Ундарга ХХК: нь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэр дээр нийт 136 ААНБ, төсөвт байгууллага, 49 орон сууцны 3 хорооллын 1490 айл өрхийн 4278 хүн амд төвлөрсөн шугамаар цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулах, гэр хорооллын 5 багийн 4750 айл өрхийн 16600 хүн амд усан сангаар дамжуулан зөөврийн цэвэр усаар хангах үндсэн үйл ажиллагааг явуулж иржээ. Үүнээс гадна сантехникийн засвар үйлчилгээ үзүүлэх, 2 халуун усны газар, автокран, трактор зэргийг бусдад түрээслүүлэх зэргээр нэмэлт орлого төвлөрүүлсэн байна. Орлогын төлөвлөлтийг хэрхэн хийснийг шалгаж үзэхэд үндсэн үйл ажиллагааны орлогыг Цэвэр усны орлого, бохир усны орлого гэж ангилан үүн дотроо ААНБ, Төсөвт байгууллага, орон сууцны айл өрх бүрээр тоолууртай,



тоолуургүйгээр ангилан, мөн зөөврийн цэвэр усны орлого, зөөврөөр зайлуулах бохир усны орлого гэж нэг бүрчлэн тооцож төлөвлөсөн байна. Ар Ус Ундарга ХХК нь 2019-2020 онд бизнес төлөвлөгөө боловсруулж усны төлбөрийн орлогыг үзүүлэлт бүрээр тооцож ажилласныг анхан шатны баримттай тулган шалгалаа.

Харин 2021 онд бизнес төлөвлөгөө боловсруулж батлуулаагүй тул анхан шатны баримтаас орлогыг төлөвлөгөөг тулгах боломжгүй байлаа. 2019-2020 оны орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй уялдуулан шалгахад төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлээгүй 2019 оны орлогын төлөвлөгөөг 72.6 сая төгрөг буюу 7%-иар, 2020 онд 9.6%-иар 2021 оны аудитлагдсан тайланд орлогыг 193.3 сая төгрөг буюу 12.0 хувиар тус тус биелүүлээгүй мэдээтэй байна. Орлого тасрах болсон нь албан байгууллагууд тоолууржиж усны хэрэглээгээ хянаж эхэлсэн, 2021 онд ковид-19 цар тахалтай холбогдуулан төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа зогсож тогтмол зардлаас хэмнэлт бий болсон зэрэг шалтгаантай байна. Орлогын 2021 оны төлөвлөгөөг 2019 онтой харьцуулахад 37.6%, 2020 онтой харьцуулахад 63%-иар тус тус өссөн байна. Энэ нь Хот суурины ус, хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 102 тоот "Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төсөвт байгууллагад мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тариф батлах тухай" тогтоолоор 2021 оны 01 сарын 01-ны өдрөөс төсөвт байгууллагуудад мөрдөх цэвэр, бохир усны тариф тн тутам 3000 төгрөг, л тутамд 3.0 төгрөг болж өссөнтэй холбоотой байна. Нөгөө талаар МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрын 211 тоот "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай"- тогтоолоор айл өрхийн цэвэр бохир усны хэрэглээг төр 100% даахаар болсонтой холбоотой байна. Хэдий айл өрхийн усны хэрэглээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулж төрөөс даахаар болсон боловч усны тоолуурын заалтад үндэслэж хэрэглээг тооцож хүргүүлэн ажилласнаас шалтгаалан усны төлбөрийн орлого 2021 онд өссөн байна. Төрөөс усны төлбөрийн орлогыг даахаар болсон шийдвэрээс шалтгаалан нэг өрхийн хоногийн хэрэгцээ 5-10л-ээр нэмэгдсэн мэдээтэй байна.

2. Цөм сүрэг ОНӨААТҮГ: Тус газрын дүрмийн 8.3.1¹²-д заасан заалтын дагуу 2019-2021 онд орлогын төлөвлөгөө гаргаагүй ажилласан бөгөөд 2019 онд 33.2 сая төгрөгийн, 2020 онд 35.7 сая төгрөгийн, 2021 онд 18.6 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Аудитаас Үйлдвэрийн газрын дүрмийн 7.2 дэх заалтын хүрээнд өөрийн орлогын төлөвлөгөөг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитой төлөвлөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

3. Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ: Тус газар нь 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө гаргаагүй харин 2020 онд 154.3 сая төгрөгөөр, 2021 онд 192.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

¹² Цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг өөрийн үйл ажилагааны орлогоос бүрдүүлнэ гэж заасан ба дүрмийн 7.2-д "Цөм сүрэг үржлийн төвийн бизнес төлөвлөгөө, цалингийн сан, урамшууллын хэлбэр, зардал, орлого, ашгийг төлөвлөж гэрээнд тусгуулан баталгаажуулна

Орлогын гүйцэтгэл 2019 онд 79.0 сая төгрөг, 2020 онд 160.2 сая төгрөг, 2021 онд 197.2 сая төгрөг буюу орлого 20*2021 онд 5.9-5.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Тус Үйлдвэрийн газрын түрээсийн төлбөрийн хэмжээг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний байгууллагуудын үнэтэй уялдуулан орлогыг нэмэгдүүлэн үр ашигтай ажиллах нь зүйтэй байна.

Энэ талаар аймгийн ОНӨГазар болон Үйлдвэрийн газрын удирдлагаас өгсөн тайлбарт тус газрын дүрэмд зааснаар аймгийн ард иргэдийн үйлдвэрлэж, бий болгосон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж, ажлын байраар хангах, гадаад дотоод худалдаа эрхлэх үндсэн зорилго чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул түрээсийн төлбөрийг нэмэгдүүлээгүй гэсэн тайлбар өгсөн.

Гэтэл аймгийн хэмжээнд ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй зарим худалдааны төвүүдийн 1 м2 талбайн нэг сарын түрээсийн төлбөр 20.0 мянган төгрөг байхад “Архангайд үйлдвэрлэв” ОНӨААТҮГазрын 1м2 талбайн түрээсийн үнэ дунджаар 13.5 мянган төгрөг байна. Үүнээс үндэслэн орлогыг тооцож үзэхэд нийт талбайн хэмжээ 1,145.5 м2*20000*12 сар= 343.6 сая төгрөгийн орлого төвлөрөхөөр байна. Энэ нь одоогийн тарифаар тооцсон дүнгээс 158.0 сая төгрөгөөр нэмэгдэх боломжтой байна.

Аудитаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн төлбөрийн хэмжээг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ижил төстэй үйлчилгээний байгууллагын тарифтай уялдуулан орлогыг нэмэгдүүлэн үр ашигтай ажиллах албан шаардлага хүргүүлээ

4. Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ: 2020 онд түрээсийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 11.8 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, 2021 онд түрээсийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 13.8 хувиар, байгууллагаас орох орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 70.5 хувиар тус тус тасарсан байна. Нийт орлогын 29.7 хувь буюу 12.9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор түрээслэгч нарын орлого буурсантай холбоотой байна.



2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд татварын орлогоор төсөвт 613.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9: Татварын орлогын гүйцэтгэл

№	Он	Байгууллагын нэр	Татварын орлого	Бусад орлого	Зөрүү
1	2019	Ар Ус Ундарга ХХК	196.9	44.6	241.5
	2020		129.7	5.7	135.4
	2021		174.9	13.8	188.7
2	2019	Цөм сүрэг	1.4		1.4
	2020		0.5		0.5
	2021		0.5		0.5
3	2019	Архангайд үйлдвэрлэв	0.01		0.0

2020	6.6	6.6
2021	39.3	39.3

Ар Ус Ундарга ХХК нь өөрөө ус ашиглагч байгууллага бөгөөд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 2 халуун усны байр иргэдэд ашиглуулж, нэмэлт орлого төвлөрүүлдэг байна. 2019-2021 онуудад нийт үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар нийт 4520 м3 ус ашиглаж **64.1** сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Харин бусад ОНӨААТҮГ-уудын хувьд төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг бүрэн төвлөрүүлэн ажилласан байна.

2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангасан эсэхэд шинжилгээ хийж ажиллахгүй байна.



2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитой хийж ажиллаагүй байна.

ОНӨААТҮГ-уудад санхүүгийн тайландаа үр ашгийн тооцоо, шинжилгээг бодитоор хийж үйл ажиллагааны зорилтот түвшинг хангаж ажиллахгүй байна. Тухайлбал:

Ар Ус Ундарга ХХК: Жил бүрийн 1-р улиралд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд тайлант жилийн усны хэрэглээний тайлангаа хүргүүлдэг байна. Тус тайланд ус ашигласны төлбөрийн орлого, зардал, тайлант жилийн зарцуулалтын тайланг тусгаж хүргүүлдэг бөгөөд энэ тайлангаар санхүүгийн үйл ажиллагааны шинжилгээг хийх бүрэн боломжтой байдаг байна. Гэтэл аудитад хамаарах хугацаанд нягтлан бодогч 2 удаа солигдсноос шалтгаалан санхүүгийн үйл ажиллагааны тооцоо судалгааг хангалттай хийгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2015 оны 12 сарын 18-ны 343 дугаар тогтоолтой нийцэхгүй байгаа бөгөөд ОНӨААТҮГ-уудад санхүүгийн үйл ажиллагаанд үр ашгийн тооцоо судалгаа хийж, ажиллах албан шаардлага хүргүүлээ.



2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, шинжилгээний үр нөлөөг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайлангийн шинжилгээ хийх нь санхүү эдийн засгийн өнөөгийн хүрсэн түвшин, ирээдүйн хандлага, санхүүгийн бодлого, санхүүгийн бололцоог үнэлэн тодорхойлж, удирдлагын оновчтой шийдвэр гарахад туслах үүрэгтэй байтал энэ шинжилгээг бодитоор хийж үр нөлөөг төлөөлөн удирдах зөвлөл болон томилох эрх бүхий байгууллагаас хийж, дүгнээгүй байна.



2.3.3. Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий гэрээг үр ашигтай хэрэгжүүлж байна уу?

Ар Ус Ундарга ХХК: 2019 оны 12 сараас эхлэн аймагт хоногт 3000м³ бохир ус татан зайлуулах хүчин чадал бүхий 7,679.4 сая төгрөгийн цэвэрлэх байгууламжийг

ЧММ ХХК барьж ашиглалтад оруулсан бөгөөд үр ашигтай хэрэгжүүлж байна. Ашиглагч байгууллага буюу Ар Ус Ундарга ХХК-аас ашиглалтын байдалд гомдол ирүүлснийг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэн шийдвэрлэх асуудлыг хүргүүлсэн. Архангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Ар Ус Ундарга” ХХК-ийн өмчид бүртгэлтэй “Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээ” ажлын хүрээнд 24-н нэр төрлийн барилга байгууламжийн ажил, холбогдон гарсан зардал нийт 8,687.4 сая төгрөгийн хөрөнгө болон зээлийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлэн бүртгэсэн байна.

Цөм сүрэг ОНӨААТҮГ: 2019 онд аймгийн ОНХСангаас Мал үржлийн нэгж байгуулах ажилд 100.0 сая төгрөгийн санхүүжилт авч тухайн ондоо аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн А/495 тоот захирамжийн дагуу 8 ААН-д аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ болон Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-тай “Үржлийн мал авах” гурвалсан гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон байна. Төрийн аудитын байгууллагаас тус газрын 2019 оны үйл ажиллагаанд эрсдлийн аудит хийж дээрх 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 21.5 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, 78.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснээс харахад тухайн хөрөнгийн зарцулалат үр ашиг муутай байгааг харуулж байна.

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ: Аймгийн Хөгжимт драмын театрттай 2020 онд 25.6 сая төгрөгийн, 2021 онд 28.8 сая төгрөгийн халаалтын үйлчилгээний хөлс авах гэрээ байгуулан байгууллагын орлогын дансанд цаг тухай бүрт нь төвлөрүүлэн ажилласан байна.

Чулуут ахуйн үйлчилгээний ОНӨААТҮГ: Тус үйлдвэрийн газрын захирал Ч.Чимэддэлэг нь 2021 оны 10 сард томилогдсон ба тус үйлдвэрийн газрын 96м2 талбайд цайны газар ажиллуудаг. 2020 оны түрээсийн гэрээгээр 5.7 сая төгрөг төлөхөөс 4.6 сая төгрөгийг төвлөрүүлж үлдэгдэл 1.1сая төгрөгийг, 2021 оны түрээсийн гэрээгээр 4.8 сая төгрөг төлөхөөс 4.7 сая төгрөгийг төвлөрүүлж үлдэгдэл 0.1 сая төгрөгийг нийт 1.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй, 2020, 2021 оны санхүүгийн тайланд авлагаар зөрүүтэй тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй байна. Мөн Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ-ын 2020-2021 онд түрээсийн гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй түрээсийн төлбөрөө дутуу төвлөрүүлсэн 6 иргэнтэй холбоотой 1.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчилд Чулуут ахуйн үйлчилгээний төвийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

2.4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа, зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж ажиллахгүй байна.



2.4.1.Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

ОНӨААТҮГ- ууд нь 2019-2021 онуудад нийт 4,314.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна. Үүнийг байгууллага тус бүрээр харуулбал:

Хүснэгт 10: Зардлын гүйцэтгэл

№	Он	Байгууллагын нэр	Зардлын				Үүнээс удирдлагын зардлын эзлэх хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	2019	Ар Ус Ундарга ХХК	1,093.3	1,103.5	(10.20)	0.93	50.0%
	2020		1,137.9	986.5	151.40	(13.31)	57.4%
	2021		1,596.6	1,476.1	120.50	(7.55)	45.2%
2	2019	Цөм сүрэг		127.9	(127.90)		5.6%
	2020			38.3	(38.30)		19.9%
	2021			21.0	(21.00)		44.4%
3	2019	Архангайд үйлдвэрлэв		70.9	(70.90)		13.9%
	2020		154.3	182.0	(27.70)	17.95	5.4%
	2021		191.6	193.7	(2.10)	1.10	5.1%
4	2020	Чулуут ахуйн үйлчилгээ	37.9	38.6	(0.70)	1.85	20.9%
	2021		45.7	35.3	10.40	(22.76)	26.8%
5	2021	Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц	38.9	38.9	-	-	100.0%
6	2021	Шилмэл сүргийн үржлийн төв	2.1	2.1	-	-	100.0%

Хүснэгтээс харахад Ар Ус Ундарга ХХК нь зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан мэт боловч орлогыг төлөвлөсөн хэмжээндээ төвлөрүүлээгүйгээс зардлын гүйцэтгэл дутуу байна. Гэсэн хэдий ч зардлыг зарцуулахдаа арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

Ар Ус Ундарга ХХК-ны 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн СХАА-наас шалгалт хийсэн байна. Тус шалгалтаар Ар Ус Ундарга ХХК нь 343.9 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч 20.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.9 сая төгрөгийн зөрчлийг цагдаагийн байгууллагад, 199.1 сая төгрөгийн зөрчлийг авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн тул зардлыг анхны шатны баримтаар тулган шалгаагүй болно. Мөн Төрийн аудитын газраас 2021 оны СТА-аар 249.8 сая төгрөгийн зөрчилд удирдлагын шийдвэргүй зориулалт бусаар зарцуулсан 2.7 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, 247.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, аймгийн ТЕЗ-д ОНӨААТҮГ-ын үр ашиг, ашигт ажиллагаа, компаний засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх албан шаардлагыг тус тус хүргүүлсэн байна.

Тухайлбал: СХАА-аас илэрсэн зөрчлөөс дурьдвал:



1. ОНӨГ-аас зөвшөөрөлгүйгээр 80.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.4¹³, Төсвийн тухай хуулийн 6.4.4¹⁴,
1. Засгийн газрын 2021 оны 43-р Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын 1.3¹⁵ дахь заалтыг зөрчиж 30.8 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан. Мөн 9.0 сая төгрөгийг хөрөнгийг худалдан аваад бүртгэлд тусгаагүй.
2. Цэвэр бохир усны нержин савыг худалдан авахдаа илүү гүйлгээ хийж 8.7 сая төгрөгийг шилжүүлсэн. Тус савыг орлогод авч бүртгэж ажлын комиссоор хүлээн аваагүй
3. Худаг, их завсарын ажил гүйцэтгэхдээ гэрээг дүгнээгүй батлагдсан төсвөөс 38.7 сая төгрөгийн илүү зарцуулалт гаргасан
4. Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй төлж барагдуулаагүй байхад гүйцэтгэх удирдлагатай холбоотой 2.2 сая төгрөгийг данс бүртгэлээс хассан
5. Гүйцэтгэх удирдлагад давуу эрх олгож 4.0 сая төгрөгийн урьдчилгааг суутгаж аваагүй
6. Ээлжийн амралтын цалин дарга, нягтлан бодогч тушаал шийдвэргүйгээр 2.5 сая төгрөгийг давхардуулан авсан
7. Эрдэнэбулган сумын 1-р сургууль, Онцгой байдлын газарт 4.5 сая төгрөгийн хандив тусламж олгосон
8. ТБОНӨХБАУАТХ-ийг зөрчиж тендер зарлалгүйгээр нүүрс худалдан авсан боловч нярав орлогод бүртгээгүй

2021 оны үйл ажиллагааны зардлын 31%-ийг дээрх алдаа зөрчил эзлэж байгаа нь удирдлагын зардлыг арвилан хэмнэлтгүй зарцуулж, оновчтой төлөвлөхгүй байна.

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ: 2020, 2021 онуудад удирдлагын зардлыг 19.8 сая төгрөгөөр төлөвлөж зарцуулсан бол 2019 онд бизнес төлөвлөгөөг батлуулаагүйтэй холбоотой 9.9 сая төгрөгийн удирдлагын зардлыг төлөвлөөгүй зарцуулсан байна.

Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ: 2019-2021 оны удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж батлуулаагүй зарцуулсан байна. Энэ нь "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ нь дүрмийн 7.2-д "Цөм сүрэг үржлийн төвийн бизнес төлөвлөгөө, цалингийн сан, урамшууллын хэлбэр, зардал, орлого, ашгийг төлөвлөж гэрээнд

¹³ төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах

¹⁴ хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох;

¹⁵ төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;

тусгуулан баталгаажуулна" гэсэн заалтын дагуу 2019-2021 онд орлогын төлөвлөгөө гаргаагүйтэй холбоотой байна.



2.4.2. Үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулж чадаагүйгээс ашиггүй ажиллаж байна.

Үйлдвэрийн газрууд нь 2019-2021 оны үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна. Тухайлбал:

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ нь 2020 онд 154.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч 182.0 сая төгрөгийг зарцуулсан, 40.3 сая төгрөгийн, 2021 онд 191.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч 193.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Эндээс харахад 2020 онд 27.7 сая төгрөгийн төсөв хэтрүүлэн зарцуулсан байгаа нь үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөөгүй, хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байгааг харуулж байна.

Үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй, үр ашигтай ажиллах албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлээ.

Цөм сүрэг үржлийн төв ОНӨААТҮГ нь нь 2019-2021 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлт, батлагдсан орон тоо, арвилан хэмнэлт гаргасан эсэхийг тулган шалгахад батлагдсан орон тоонд нийцүүлэн цалин хөлсийг олгосон хэдий ч бусад зардлын хувьд санхүүгийн төлөвлөгөө гаргаагүй 39.5 сая зарцуулалт гаргасан байна. Эндээс харахад "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ нь ТБОНӨТХ-н 20 дугаар зүйлийн 20.3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", үржлийн төвийн дүрмийн 7.4-д "Жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тайлагнана" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Үйл ажиллагааны зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй, үр ашигтай ажиллах албан шаардлага хүргүүлэх

Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ: Тус үйлдвэрийн газар нь батлагдсан төсвийн 2020 онд 22.5 хувийн 2021 онд 3.2 хувийн нийт 25.7 хувь буюу 9.8 сая төгрөгийг хэтрүүлж арвилан хэмнэлттэй, зориулалт бусаар, үр ашиггүй зарцуулсан байна. Мөн 2020 оны санхүүгийн тайлангаар 6.7 сая төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүсгэсэн ба 2021 оны санхүүгийн тайлангаар 3.6 сая төгрөгийн байгууллага, иргэнд төлөх өртөлбөр нэмэгдэж нийт 10.4 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй болсон үүссэн ба барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.



2.4.3. Төлөвлөгдөөгүй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тооцож, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахгүй байна.

Ар Ус Ундарга ХХК: 2019-2020 онуудад шаардлагатай хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийг ТУЗ-аар батлуулж, жилийн дундуур нэмэлт өөрчлөлтийг хийлгэж ажилласан байна. Гэтэл 2021 онд ТУЗ-гүй ажилласнаар хөрөнгө оруулалтын
АРА-2022/22-1/ШТА-ГА

зардлыг гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр захиран зарцуулж, түүнд тавих хяналт байхгүйгээс гэрээ байгуулж төлөвлөсөн зардлаас илүү зарцуулалт гаргажээ. Энэ нь хөрөнгө оруулалтын гэрээг үр ашигтай хэрэгжүүлж чадаагүй зардалд хэт үрэлгэн хандснаас шалтгаалан алдагдалтай ажиллах нэг нөхцлийг бүрдүүлсэн байна.

Архангайд үйлдвэрлэв ОНӨААТҮГ : Үйлдвэрийн газар нь 2019 онд 11.9 сая төгрөгийн, 2020 онд 17.8 сая төгрөгийн, 2021 онд 2.3 сая төгрөгийн нийт 32.0 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Үүнээс хэрэгцээ шаардлагад үндэслээгүй бизнес төлөвлөгөөнд тусгаагүй 2019 оны 11.9 сая төгрөг, 2020 оны 12.3 сая төгрөг, 2021 оны 2.3 сая төгрөг нийт 26.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь тухайн байгууллага шаардлагатай үндсэн хөрөнгийг олж бэлтгэхдээ холбогдох хууль журам дүрмийн дагуу үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авсан байгааг харуулж байна.

Харин “Цөм сүргийн үржлийн төв” нь 2019-2021 онд хөрөнгө бэлтгээгүй байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бодитой тооцож тухайн жилийн төсөвт суулган батлуулж байх албан шаардлагыг холбогдох газруудад хүргүүллээ.

Чулуут ахуй үйлчилгээний төв ОНӨААТҮГ нь тухайн жилийн төсөвт батлагдаагүй дараах арга хэмжээнд зарцуулалт гаргасан байна. Үүнд: 2020 онд 1.7 сая төгрөгийн, 2021 онд 1.0 сая төгрөгийн нийт 2.7 сая төгрөгөөр төлөвлөгдөөгүй хөрөнгө худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.



3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тавих хөндлөнгийн хяналт хангалттай байгаа ч, үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.



3.1.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ, Засаг дарга, ОНӨГ-аас тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна./ Эх сурвалж: ОНӨГ-ын 2021 оны 06 сарын 06-ны 330 тоот албан бичиг/



3.1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байгаа ч хүргүүлсэн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Ар Ус Ундарга ОНӨХХК: Тус компаний үйл ажиллагаанд аймгийн СХАА-наас 2019 онд хэсэгчилсэн, 2020 онд 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Татварын хэлтсээс 2020 онд тус тус хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

“Архангайд үйлдвэрлэв” худалдааны төв, “Цөм сүрэг үржлийн төв” ОНӨААТҮГ: Тус газруудын үйл ажиллагаанд 2019 онд Төрийн аудитын байгууллагаас эрсдлийн аудит, 2021 онд СХАА-аас төлөвлөгөөт шалгалт тус тус хийсэн байна.

Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨАТҮГ: Тус байгууллагын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын хяналт хийгдээгүй байна

Хүснэгт 10: 2019-2021 онуудад ОНӨАТҮГ-уудад хяналт шалгалтыг хийсэн байдал

Он	Байгууллагын нэр	Хяналт хийсэн байгууллага					
		Төлөвлөгөөт	Шийдвэрийн		Хуулийн дагуу	Шийдвэрийн	
			Тоо	Мөнгөн дүн		Тоо	Мөнгөн дүн
2019	Ар Ус Ундарга	СХАА	2	28.6	Төрийн аудитын газар	4	190.7
	Архангайд үйлдвэрлэв	Төрийн аудитын газар /Эрсдлийн аудит/	8	46.6			
	Цөм сүрэг					1	233.7
	Чулуут ахуйн үйлчилгээний төв	Хяналт хийгдээгүй					
2020	Ар Ус Ундарга	Татварын хэлтэс	1	4.2	Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК	3	7,743.50
	Архангайд үйлдвэрлэв	СХАА	2	34.5		5	27.8
	Цөм сүрэг		3	4.2		5	11.5
	Чулуут ахуйн үйлчилгээний төв	Хяналт хийгдээгүй			Монголиан бизнес рейтинг		
2021	Ар Ус Ундарга	СХАА	14	343.9	Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК	11	249.8
	Архангайд үйлдвэрлэв	Хяналт хийгдээгүй				4	7.4
	Цөм сүрэг					4	13.4
	Чулуут ахуйн үйлчилгээний төв	Хяналт хийгдээгүй			Монголиан бизнес рейтинг		

ОНӨАТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийх төрийн байгууллагуудын хяналт хангалттай байгаа боловч хүргүүлсэн шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байна. Учир нь санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтаар илэрдэг алдаа зөрчил давтагдаж, холбогдох байгууллагаас хүргүүлж байгаа шийдвэрүүдийг хэрэгжүүлэхгүй, зардлыг зориулалт бусаар зарцуулдаг, хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт гаргадагаас шалтгаалан тус байгууллагын үр ашиг дээшлэхгүй жил тутам алдагдалтай ажилласан байна.

Ар Ус Ундарга ХХК: 2020-2021 оны үйл ажиллагаанд хийсэн СХАА-ны шалгалтаар нийт 343.9 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 20.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 123.9 сая төгрөгийн зөрчлийг цагдаагийн байгууллагад, 199.1 сая төгрөгийн зөрчлийг авилгатай тэмцэх газарт шилжүүлсэн, Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар СТА-аар 249.8 сая төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг хүргүүлж, аймгийн ТЕЗ-д ОНӨАТҮГ-ын үр ашиг, ашигт ажиллагаа, компаний засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨАТҮГ: 2019 оны үйл ажиллагаанд Төрийн аудитын газраас хийсэн эрсдлийн аудитаар нийт 46.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 0.4 сая төгрөгт төлбөрийн акт тогтоон, 43.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах албан шаардлага, 2.6 сая төгрөгийн зөрчилд 6 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн, 2018-2020 оны үйл ажиллагаанд хийсэн СХАА-ны шалгалтаар нийт 34.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 27.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн, 2019-2021 оны Төрийн аудитын газрын СТА-аар нийт 35.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 11.3 сая төгрөгийн зөрчил албан шаардлага, 23.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

“Цөм сүрэг үржлийн төв” ОНӨААТҮГ: 2019 оны үйлд ажилдлагаанд ТАГ-аас хийсэн эрсдлийн аудитаар 100.0 сая төгрөгийн зөрчил илэрч 21.5 сая төгрөгийн зөрчилд орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, 78.5 сая төгрөгийн зөрчилд гэрээний хугацаа болон эргэн төлөлтийг байгууллага бүрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах 1 заалт бүхий, байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн, 2017-2020 оны үйл ажиллагаанд хийсэн СХАА-ны шалгалтаар нийт 4.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 4.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн, 2019-2021 оны СТА-аар ТАГ-аас нийт 258.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 254.5 сая төгрөгийн зөрчил албан шаардлага, 4.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна.



3.2.1. ТУЗ-ын дэргэдэх дотоод аудит, эрсдэлийн удирдлагыг Ар Ус Ундарга ОНӨХХК хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүр хийдэг СТА-аар Ар Ус Ундарга ХХК-ний дотоод хяналтын эрсдлийг Их гэж үнэлсэн байна. СХАА-аас 2020-2022 оны 1-р улирлын байдлаар хийсэн хяналт шалгалтын тайланд байгууллагын дотоод хяналтын нэгжийг томилж, журам төлөвлөгөөг баталсан ч санхүүгийн чиглэлээр дотоод хяналт хийгдээгүй зөвхөн үйл ажиллагааны чиглэлд хяналт шалгалт хийсэн гэх боловч аудитын явцад дотоод хяналтын хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг ирүүлээгүй, ТУЗ-ийн дэргэд дотоод хяналтын хороо байгуулж ажиллаагүй байна.



3.2.2. Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт, эрсдэлийн удирдлага хангалтгүй байна.

ОНӨААТҮГ-дад МУЗГ-ын 2011 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналт, шалгалтыг аудитад хамаарах хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Аудитаас гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, ажлын төлөвлөгөө гарган үр дүнг тухай бүр танилцуулж ажиллах албан шаардлагыг ОНӨААТҮГ-уудад хүргүүллээ.

3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг ханган ажиллаж чадахгүй байна.



3.3.1. Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцоо муу, харилцан уялдан ажиллаж чадахгүй байна.

Төрийн байгууллагуудын мэдээлэл харилцан уялдаагүй, аймгийн ИТХ болон засаг дарга, ОНӨГ-аас орон нутгийн өмчит хуулийн этгээдийг мэргэжлийн бодлого арга зүйгээр хангаж, мэдээлэл солилцон хамтран ажиллах байдал хангалтгүй байна.



3.3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн мэдээлэл ил тод, нээлттэй бус байна.

ОНӨААТҮГ-ууд нь мэдээллийн ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулинд нийцүүлж байгаагаас өөрөөр ил тод байдлыг хангаагүй албан ёсны вэб хаяггүй, иргэдийн сонирхол бүхий мэдээллийг олон нийтэд нийтлээгүй үйл ажиллагааны хувьд иргэд олон нийт мэдээлэлээр дутмаг байна. Тухайлбал:

- ✓ Ар Ус Ундарга ХХК нь албан ёсны вэб хаяггүй, ТУЗ-ын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг огт мэдээлээгүй.
- ✓ “Архангайд үйлдвэрлэв” худалдааны төв, “Цөм сүрэг үржлийн төв”-үүд нь үндсэн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллээр олон нийтэд мэдээлж байна. Мөн Архангайд үйлдвэрлэв Худалдааны төв нь өөрийн Facebook хуудсаараа байгууллагын үйл ажиллагааг сурталчилан таниулж ажилласан

Иймд аудитаас ОНӨААТҮГ-дад ил тод байдлыг хангаж, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд танилцуулж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ОРОН НУТАГТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

- 3.1. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаний засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.
- 3.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГГҮЙ БАЙНА.

- 2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, батлахгүй байна.
- 2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй байна.
- 2.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилт түвшнийг хангасан эсэхэд шинжилгээ хийж ажиллахгүй байна.
- 2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж ажиллахгүй байна.

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

- 3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тавих хөндлөнгийн хяналт хангалттай байгаа ч, үр нөлөөтэй хэрэгжүүлэхгүй байна.
- 3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчгүй, хяналт үр нөлөөгүй байна
- 3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг ханган ажиллаж чадахгүй байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Аудитаар 4 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой **566.7** сая төгрөгийн **26** алдаа зөрчил илэрч **2.5** сая төгрөгийн **1** зөрчилд төлбөрийн акт, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад чиглэсэн **564.2** сая төгрөгийн **18** зөрчилд албан шаардлага, арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн **7** зөвлөмжийг Засаг дарга, ОНӨГ, Ар Ус Ундарга ХХК, Архангайд үйлдвэрлэв, Цөм сүрэг, Чулуут ахуйн үйлчилгээний төв ОНӨААТҮГ-уудад хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн холбогдох байгууллагуудад дараах зөвлөмжийг хүргүүлээ.

Аймгийн засаг дарга М.Батжаргал, ОНӨГ-ын дарга Х.Ганхуяг танаа:

1. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, харилцан мэдээлэл солилцож хамтран үр ашигтай ажиллах
2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд заасны дагуу дотоод хяналт шалгалтыг хийж, үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллах

Ар Ус Ундарга ХХК-ний захирал С.Баатархуяг танаа:

1. Эрдэнэбулган сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг айл өрх, албан байгууллагыг тоолууржуулж, усны алдагдлыг хянаж, төсөвлөсөн орлогыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах
2. Мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд байгууллага болон ТУЗ-ын үйл ажиллагааг тайлагнаж хэвших
3. ИТХ-аар батлуулсан Ар Ус Ундарга ХХК-ний дүрэмд анализ хийж, өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт 2022 оны 12 сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.